




GENCO TOUR
BUREAU JSC

ЖЕНКОТУР БЮРО ХК
2019 ОНЫ ТАЙЛАН


АГУУЛГА

1. Компанийн 2019 оны төсвийн гүйцэтгэл.
 - Борлуулалтын орлого
 - Шууд зардал
 - Цэвэр ашиг
 - Нийт үйл ажиллагааны зардал
 - Татварын өмнөх ашиг
2. Үйл ажиллагааны тайлан
 - Маркетингийн алба
 - Аялын алба
 - Хүний нөөцийн алба

- Борлуулалтын орлого (мян.₮)




- 2019 оны борлуулалтыг 2018 оны төсвийн борлуулалттай харьцуулахад -2% бууралттай гарсан.
- 2019 оны борлуулалтыг 2019 оны төсөвтэй харьцуулахад 17%-ийн өсөлттэй гарсан байна:



- 2-р улиралын борлуулалтын орлогод голлох нөлөөлсөн бүтээгдэхүүн нь ЧХМХ болон Гадаад аялал байгаа бол 3-р улиралын борлуулалтын орлогод гол нөлөөлсөн бүтээгдэхүүн нь ЧХМХ цогцолбор байна.

- Борлуулалтын орлого (мян.₮)

Борлуулалтын орлогын бүтэц




Төрөл	Дүн	Хувь
ЧХМХ	2,886,053.9	61%
13-р зуун цогцолборын	457,742.7	10%
Гадаад аялал	881,168.3	19%
Дотоод аялал	477,241.4	10%

Нийт дүн: 4,702,206.3

- Нийт борлуулалтын орлогын дийлэнх буюу 61%-ийг ЧХМХ цогцолбор бүрдүүлж байгаа бөгөөд 19%-ийг гадаад аялал, 10%-ийг 13-р зуун цогцолбор болон 10%-ийг Дотоод аяллын борлуулалт тус тус эзэлсэн байна.

- Борлуулалтын орлого (мян.₮)

ЧХМХ цогцолборын борлуулалтын орлогын бүтэц




- 87% Үзвэрийн орлого | 2,521,060.7
- 5% Ресторан, хоолны орлого | 153,085.9
- 5% Түрээсийн орлого | 137,476.4
- 2% Текний орлого | 51,796.8
- 1% Гэрийн орлого | 17,225.1
- 0% Бусад орлого | 5,409.1

Нийт дүн: 2,886,053.9

- Нийт борлуулалтын орлогын 61%-ийг бүрдүүлсэн ЧХМХ цогцолборын борлуулалтын орлогыг дэлгэрэнгүй харвал 87%-ийг Үзвэрийн орлого эзлэж байна.

- Борлуулалтын орлого (мян.₮)

13-р зуун цогцолборын борлуулалтын орлогын бүтэц



-
- 51% Үзвэрийн орлого | 234,920.8
 - 23% Гэрийн орлого | 107,295.3
 - 22% Ресторан, хоолны орлого | 98,543.6
 - 3% Малын ашиг шим | 14,519.3
 - 1% Бусад орлого | 2,463.6
-


Нийт дүн: 457,742.7

- Нийт борлуулалтын орлогын 10%-ийг бүрдүүлсэн 13-р зуун цогцолборын борлуулалтын орлогыг дэлгэрэнгүй харвал 51%-ийг Үзвэрийн орлого, 23%-ийг гэр, 22% ресторан, хоолны орлого эзлэж байна.

- Борлуулалтын орлого

ЧХМХ, 13-р зуун цогцолборын Рестораны орлого, зардал

Ресторан тус бүрийн борлуулалтыг зардалтай (Хүнсний зардал + Ажилчдын хүнсний зардал) харьцуулан үзэхэд нийт борлуулалтын орлогын 52% хүнсний зардалд гарч байна.



	ЧХМХ	13-р зуун	Нийт дүн
Хоолны орлого	153,085,902.0	98,543,660.0	251,629,562.0
Хүнсний зардал	71,851,581.0	26,359,209.0	98,210,790.0
Ажилчдын хүнсний зардал	19,168,021.0	13,749,573.0	32,917,594.0
Ашиг	62,066,300.0	58,434,878.0	120,501,178.0

- Борлуулалтын орлого

Зочдын тоон үзүүлэлт


ЧХМХЦ					13-р зуун				
Сар	Хүүхэд	Том хүн	Гадаад	Нийт хүн	Сар	Хүүхэд	Том хүн	Гадаад	Нийт хүн
1	635	3,271	1,146	5,052	1	39	29	11	79
2	460	2,986	1,250	4,696	2		15	21	36
3	1,010	4,190	2,256	7,456	3	66	158	79	303
4	681	3,912	2,770	7,363	4	103	72	102	277
5	489	3,093	5,564	9,146	5	6	278	355	639
6	1,463	7,581	9,369	18,413	6	385	584	725	1,694
7	3,638	13,427	16,647	33,712	7	138	819	1,018	1,975
8	2,606	9,816	14,990	27,412	8	120	968	1,188	2,276
9	516	3,847	7,819	12,182	9	188	502	725	1,415
10	541	2,665	3,778	9,684	10	37	142	223	402
11	431	3,379	1,662	5,472	11	3	25	27	55
12	214	1,902	1,050	3,166	12	18	29	21	68
Дүн	12,684	60,069	68,301	141,054	Дүн	1,103	3,621	4,495	9,219

Нийт			
Хүүхэд	Том хүн	Гадаад	Нийт хүн
13,787	63,690	72,796	150,273

- Зочдын тоон үзүүлэлт нь 5 сараас идэвхжиж эхлэн 7,8-р сар оргил үе болж 9,10-р саруудад буурч байна. Энэ нь үндсэн бүтээгдэхүүн буюу ЧХМХ, 13-р зуун цогцолборууд болон дотоод аяллын бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, намар, өвөл, хаврын улиралд хүний урсгал татах шинэ бүтээгдэхүүн гаргах шаардлагатай байгааг харуулж байна.

- Борлуулалтын орлого (мян.₮)

Гадаад аяллын борлуулалтын орлогын бүтэц




ГАДААД АЯЛАЛ				
№	Чиглэл	Орлого	Зардал	Ашиг
1	Сингапур	509,889.4	688,440.0	(178,550.6)
2	Солонгос	126,171.3	123,271.1	2,900.2
3	Тайланд	64,307.6	62,910.3	1,397.3
4	Бали	52,070.0	52,627.6	(557.6)
5	Хайнан	35,200.0	34,191.8	1,008.2
6	Бусад аялал	31,900.0	34,562.4	(2,662.4)
7	Дубай	31,420.0	30,684.1	735.9
8	Вьетнам	17,750.0	16,907.2	842.8
9	Хятад	12,460.0	11,024.1	1,435.9
НИЙТ ДҮН		881,168.2	1,054,618.6	(173,450.3)

- Гадаад аяллын борлуулалтын орлогын дийлэнх буюу 58% Сингапур аялал эзлэж байгаа бол 20%-ийг зүүн өмнөд азийн орнууд, 14% Солонгос улс тус тус эзлэж байна.
- Гадаад аяллын алдагдалын эх үүсвэр нь Сингапур аяллын орлогын 45,878 долларын асуудал мөн өмнөх жилүүдийн гадаад аялал дээр хуримтлагдсан нийт 6,546,091 төгрөг бүхий бартерийн тооцоог оруулсан нь тус тус нөлөө үзүүлж байна.

- Борлуулалтын орлого (мян.₮)

Дотоод аяллын борлуулалтын орлогын бүтэц




ДОТООД АЯЛАЛ				
№	Чиглэл	Орлого	Зардал	Ашиг
1	Сунгапур	391,161.8	275,885.4	115,276.4
2	G150	89,939.5	67,688.9	22,250.6
3	Holt tour	29,866.5	22,717.0	7,149.5
4	Ай Номадик	13,600.0	10,654.8	2,945.2
5	Бид хамтдаа	11,167.0	10,050.3	1,116.7
6	Бэсрэг Наадам	5,959.6	2,288.6	3,671.0
7	Бусад	4,917.1	3,174.9	1,742.2
8	Түүхийн жим	2,127.3	1,799.7	327.6
НИЙТ ДҮН		548,738.75	394,259.58	154,479.17


- Дотоод аяллын борлуулалтын орлогын 71%-г Сингапур, 16%-г G150 аялал эзлэж байгаа бөгөөд бусад аяллууд нийлээд 12%-г эзлэж байгаа нь цаашид бусад орнуудаас жуулчид татах үйл ажиллагаанд анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.

- Шууд зардал (мян. ₮)

Шууд зардал
(Нийт дүнгээр)




Шууд зардал
(Улиралаар)



- 2019 оны шууд зардлын төсвийг 2018 оны шууд зардлын төсвөөс 19%-иар бууруулж төлөвлөсөн ба 2019 оны төсөвлөсөн шууд зардал 95%-тай биелсэн байна.
- 2019 оны шууд зардлын гүйцэтгэлийг 2018 оны шууд зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад 30% буурсан үзүүлэлт гагсан байна.


- 2019 оны шууд зардлыг улиралаар задлан харвал дийлэнх буюу 1,4 тб төгрөг 49% нь 2-р улиралд гарсан ба үүнээс 689,2 сая төгрөг 49% нь гадаад аялал (Сингапур чартер) – ын зардал байна.

- Цэвэр ашиг (мян.₮)



- 2019 оны цэвэр ашгийн төсвийг 2018 оны төсвөөс 88%-иар нэмэгдүүлж төлөвөлсөн ба 2019 оны төсвийн гүйцэтгэл нь 181%-иар биелсэн байна.
- 2019 оны цэвэр ашгийн гүйцэтгэлийг 2018 оны цэвэр ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад 258%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.


Цэвэр ашиг
(Улиралаар)




- 2019 оны цэвэр ашгийг улиралаар задлан харвал дийлэнх буюу 1,4 тб төгрөг 80% нь 3-р улиралд гарсан ба үүнээс 90% нь ЧХМХ цогцолборын үйл ажиллагаа эрчимжсэнтэй холбоотой байна.

- Нийт үйл ажиллагааны зардал (мян.₮)

Нийт үйл ажиллагааны зардал
(Нийт дүнгээр)



Нийт үйл ажиллагааны зардал
(Улиралаар)




- 2019 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 2018 оны төсвөөс 39%-иар нэмэгдүүлж төлөвөлсөн ба 2019 оны төсвийн гүйцэтгэл нь 113%-иар биелсэн байна.
- 2019 оны төсвийн гүйцэтгэлийг 2018 оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 19%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.

- 2019 оны нийт үйл ажиллагааны зардлыг улиралаар задлан харвал 23%-аас 27%-тай жигд байсан бөгөөд дунджаар 105,781.5 төгрөг байна.

- Нийт үйл ажиллагааны зардал (мян.₮)


Нийт үйл ажиллагааны зардал
(Бүтцээр)



- Нийт үйл ажиллагааны зардлыг задлан харвал 47%+6% буюу нийт 53%-ийг Цалин, урамшуулал, ЭМ, НДШимтгэлд зарцуулсан байна.
- Мөн 10% Төлбөр хураамж, бусад зардал, 10% оффисын элэгдлийн зардалд зарцуулсан байна.


- Татварын өмнөх ашиг (мян.₮)

Татварын өмнөх ашиг
(Нийт дүнгээр)



- 2019 оны татварын өмнөх ашгийн төсвийг 2018 оны төсвөөс 163%-иар нэмэгдүүлж төлөвөлсөн ба 2019 оны төсвийн гүйцэтгэл нь 216%-иар биелсэн байна.
- 2019 оны татварын өмнөх ашгийг 2018 оны татварын өмнөх ашигтай харьцуулахад 593%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.

Татварын өмнөх ашиг
(Улиралаар)



- 2019 оны нийт татварын өмнөх ашгийг улиралаар задлан харвал 99% нь 3-р улиралд байсан нь бөгөөд ЧХМХ цогцолборын үйл ажиллагаа эрчимжсэнтэй холбоотой байна.
- Мөн 1, 4-р улиралд алдагдалтай гарсан нь цаашид бизнесийн бусад хэсгүүдэд анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

2. Үйл ажиллагааны тайлан

- Маркетинг

№	Гүйцэтгэсэн голлох ажлуудын хураангуй
1	2018 оны компаний тайланг нэгтэн, ном болгож холбогдох газруудад хүргэсэн
2	2019 оны компанийн хагас жилийн тайлан боловсруулж холбогдох газруудад мэдээлэл хүргэсэн
4	2 удаагийн хуримын үзэсгэлэнд оролцсон
5	Сингапур, Малайзын аяллын Маркетинг борлуулалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн
6	Хаан банктай хамтарсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн
7	Байгууллагын (гуравдагч талгүй) зээлийн бүтээгдэхүүн боловсруулж туршсан
8	Facebook ChatBot-н систем нэвтрүүлсэн
9	4-р улиралын үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулсан
10	Гадаад аяллын нэгдсэн маркетингийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна

2. Үйл ажиллагааны тайлан

- Маркетинг

№	Гүйцэтгэсэн голлох ажлуудын хураангуй
11	“Түүхийн жимээр” богино аялал зохион байгуулсан
12	“Бид хамтдаа” аяллын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжүүлсэн
13	Алтан ташуур рестораны меню шинэчлэх, байршуулсан
14	Наадмын тасалбартай тусгай хөтөлбөр хэрэгжүүлсэн
15	2 цогцолборын ваучерын дизайныг шинэлчэн хэвлүүлсэн
16	Сошиал маркетингийн өдөр тутмын хяналт, хөтлөлт хийгдсэн
17	Ажлуудтай холбоотой график дизайны ажлуудыг гүйцэтгэсэн

2. Үйл ажиллагааны тайлан

- Арга хэмжээ /Event/

№	Арга хэмжээ	Орлого	Зарлага	Ашиг
1	G 150	89,939,505	67,688,886	22,250,619
2	I Nomadic	13,600,000	10,654,800	2,945,200
3	Coal mongolia	5,959,650	2,288,600	3,671,050
4	Талын салхи	16,849,000	13,490,227	3,358,773
5	Хүннү Мюзик Цогцолборын борлуулалт	17,012,900		
6	Hollywood in Mongolia	Хамтран зохион байгуулагч, ивээн тэтгэгч		
7	Чингисийн үрсийн баяр Цогцолборын борлуулалт	23,162,569		
8	Түүхийн жимээр аялал Ивээн тэтгэгч 3 саяын дэмжлэг	2,127,250	1,799,660	327,590

- G150 арга хэмжээний “зарлага”-ын 14,313,600₮ буюу 21% нь цаашид ашиглах гэр, хөргөгч зэрэг худалдан авалтууд багсан.

2. Үйл ажиллагааны тайлан (Хураангуй)

- Аялал (Гадаад)

Гадаад аялал: **11** төрлийн чиглэлд аялал зарласан бөгөөд нийт **18** аялал гарч **309** хүн аяласан байна.



№	Чиглэл	Жуулчны тоо
1	Бали	14
2	Бали	15
3	Тайланд Пукет	18
4	Тайланд	31
5	Тайланд	5
6	Тайланд	12
7	Тайланд	8
8	Ханой Вьетнам	3
9	Ханой Вьетнам	5
10	Хайнан	4
11	Хайнан	2
12	Хайнан	6
13	Хайнан	2
14	Хайнан	6
15	Дубай	1
16	Дубай	3
17	Бээжин	14
18	Сингапур, Тайланд	160
НИЙТ ДҮН		309

2. Үйл ажиллагааны тайлан (Хураангуй)

- Аялал (Дотоод)



№	Чиглэл	Жуулчны тоо
1	Сингапур	176
2	АЙ Номадик	150
3	G150	95
4	Holt tour	33
5	Бид хамтдаа	664
6	Бэсрэг Наадам	21
7	Түүхийн жим	43
8	Бусад	2
НИЙТ ДҮН		1184

Дотоод аялал: **8** төрлийн аялал зохион байгуулж гарч **1184** хүн аялалд хамрагдсан байна.

2. Үйл ажиллагааны тайлан

• Хүний нөөцийн голлох ажлууд

№	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны дагуу хийгдсэн ажлууд	Гүйцэтгэл	Дүгнэлт /гайлбар/
1	Шинээр батлагдаж буй бүтэц орон тоон дээр хүний нөөцийн төлөвлөлтийг боловсруулах	Улирлын нээлтийн үйл ажиллагаа эхлэхэд бэлтгэл ажил хийгдэх 2019 онд батлагдсан бүтцийн дагуу болон цогцолборын менежертэй хамтран 2 цогцолбор дээр улирлын үед ажиллах хүний нөөцийг алба, албан тушаалын дагуу жагсаалт гарган бүрдүүлэлт хийсэн	80%	Улирлын үед гэрээт ажилтан болон оюутнаар орон тоог нөхөж ажилласан ба 9 сард хичээл ороход ажлын байрны бүрдүүлэлт буурч сул ажлын байрууд 9 10 сард нэмэгдсэн.
2	Аялал жуулчлалын боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж амжилттай төгсөгчдийг ажлын байраар хангаж, компанийн үйл ажиллагааг сурталчилах	Их дээд сургуулиад аялал жуулчлалын тэнхимтэй хийгдсэн хамтран ажиллах гэрээний дагуу албан бичиг хүргүүлэн аялал жуулчлалын ангиадуус төгсөх курс болон дадлагад гарах ангиудаас оюутнууд цалинтай дадлага хийлгэх болон зуны хугацаанд ажлуулахаар тохиролцон холбогдсон. Мөн Ражив Гандийн нэрэмжит үйлдвэрл урлалын политехник коллежийн зочид буудал аялал жуулчлалын ажилтны 2-р курсын оюутнуудыг ажиллуулахаар тохиролцож ажилласан.	85%	Урд жилүүдэд зуны амралтаараа 2 цогцолборт ажиллаж байсан оюутнууд болон Отгонтэнгэр их сургуулийн англи хэлний багш орчуулагчийн ангийн оюутнуудаас ачааллын үед авч ажиллуулсан энэ нь хэлний мэдлэггүй аяллын ангийн оюутнууд ажиллуулснаас давуу тал үүссэн.
3	Нийт ажилчдыг хамруулан сургалт зохион байгуулах	Ганабелл сургалтын төвтэй хийсэн бартерийн гэрээгээр нийт ажилчдыг хамруулан 6 цагийн үйлчилгээний ажилчдад зориулсан сургалт, мөн Консумер сургалтын төвтэй хамтран “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал зуршил” сургалтыг амжилттай зохион байгуулсан.	50%	Алба тус бүрээр сургалтын хэрэгцээг судлан хувь хүний хөгжил болон тухайн ажлын байрны шаардлагын дагуу сургалт зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзсэн.
4	Албан тушаалд шаардлагатай ур чадварыг тодорхойлох	шилжүүлэн ажлуулсан ажилтнуудын ур чадварыг сайжруулах үүднээс мэргэжлийн хүмүүст хариуцуулан ажлын байран дээрхи ур чадварыг суулгуулсан	100%	шинэ ажилтанг тухайн албан тушаалд зохицох, байгууллага таниж мэдэх хугацаа өгөх нь тухайн хүн ур чадвараа бүрэн гаргах боломжтой болно.

2. Үйл ажиллагааны тайлан

• Хүний нөөцийн голлох ажлууд

№	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны дагуу хийгдсэн ажлууд	Гүйцэтгэл	Дүгнэлт /гайлбар/
5	Зэрэг дэвийн тогтолцоог боловсронгуй болгох	Чингис хааны морьт хөшөөт цогцолбор дээр нийт ажилтнуудын дунд 2 удаа нэгбүрчлэн 3 удаа, 13-р зуун цогцолборт нийт ажилтнууд дунд 5 удаа, ажилтан нэг бүрчлэн 2 удаа хурал хийн байгууллагад мөрдөгдөж байгаа журам хийгдэх ажлуудыг танилцуулан удирдах удирдуулах ёс болон ажлын байран дээрхи баримтлах дэг журамыг танилцуулан ажилласан.	100%	удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож удирдлагатай харилцах шат дараалал үүсгэн ажилчдад танилцуулах. Ингэснээр цогцолборын менежерүүд менежерийн түвшинд ажиллах боломжтой болно.
6	Ажилтнуудын гавьяа шагналуудын талаар судалгаа хийж, мэдээллийг тухай бүр шинэчлэж байх	Үндсэн ажилчдын дунд 5-аас дээш жил ажилласан ажилчдын судалгааг авч байсан гавьяа шагналын судалгаатай нэгтгэн хийж танилцуулсан. Гүйцэтгэх захирлын шийдвэрээр Монголын эмэгтэйчүүдийн холбооны Хүндэт тэмдэг, Дурсгалын тэмдэгээр 2 ажилтанг шагнасан. Мөн Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хүндэт тэмдэгээр 5 ажилтанг тодорхойлсон.	80%	хөдөлмөрийн дотоод журамд шагналын талаар дэлгэрэнгүй оруулж өгөх
7	Нийт ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулан эрүүл мэндийн төвшинг тогтоон өвчлөлийг эрт оношлон хүндрэхээс урьдчилан сэргийлэх	СБД-ийн манай харьяаны өрхийн эмнэлэг шатан санхүүжилт дэмжлэг хүссэний дагуу санхүүжилтийн оронд эмнэлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэхээр харилцан тохиролцож урьдчилан сэргийлэх үзлэгийг Чингис хааны морьт хөшөөн дээр зохион байгуулан 2 цогцолборын нийт ажилтнуудыг хамруулсан. оффисийн ажилчдыг хотод байрладаг өрх дээр зохион байгуулан зарим нэг багаж тоног төхөөрөмж дутуугаас бүрэн хамрагдаагүй хүлээлтийн байдалтай байна.	90%	өвчлөлийн зэрэг 10% -аас бага гэсэн үзүүлэлт гарсан.

2. Үйл ажиллагааны тайлан

• Хүний нөөцийн голлох ажлууд

№	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны дагуу хийгдсэн ажлууд	Гүйцэтгэл	Дүгнэлт /тайлбар/
8	Нийтээр тэмдэглэх баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг нийт ажилчдыг хамруулан тэмдэглэх	хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд 16 наснаас доош насны хүүхдийн судалгаа гарган гарын бэлэг гадуулсан. Мөн цагаан сараар ахмад тэтгэвэрт гарсан өндөр настай 2 ажилтанд гарын бэлэг гардуулсан. Шинэ жилийг тэмдэглэн өнгөрүүлэх комисс томилон нийт 39 ажилтанг хамруулан урамшуулал гарын бэлэг гардуулсан.	100%	
9	Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартаар ажлын байран дээрхи анхан болон давтан сургалт зохион байгуулах	Хөдөлмөр эрүүл ахуй ажилгүй ажиллагааны зааварчилгааг шинээр боловсруулан мөрдүүлж өдөр болгон зааварчилгаа өгүүлж гарын үсэг зуруулан хэвшүүлсэн.	100%	Аюулгүй ажиллагааг мэргэжил тус бүр дээр нарийвчлан гаргаж ажиллахаар 2020 онд төлөвлөөд байна.
10	Ажлын байранд баримтлах ёс зүйн дүрэм журмыг сайжруулан мөрдүүлэх	2 цогцолборт мөрдөгдөх дотоод журам болон дотоод хяналтын журамыг боловсруулан мөрдүүлж ажиллаж байна	100%	2 цогцолбор дээр мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн дотоод журамтай уялдуулан шинэчлэх
11	Шаардлагатай дүрэм журмыг тухай бүрд боловсруулан ажилтнуудад сурталчилан таниулах	Хөдөлмөрийн дотоод журмыг 2018 оны 11 дүгээр сараар батлагдсанг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж сурталчилан 2019 оны байдлаар 2 удаа нийт ажилчдад болон ганцаарчлан танилцуулж ажилласан	100%	

2. Үйл ажиллагааны тайлан

- Хүний нөөцийн голлох ажлууд

№	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны дагуу хийгдсэн ажлууд	Гүйцэтгэл	Дүгнэлт /тайлбар/
12	Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй бүх дүрэм, журмын хэрэгжилтийг бүрэн хангуулах	2019 оны байдлаар хөдөлмөрийн дотоод журмын дагуу нийт ажилчдад нэмэгдэл олгогдон төрсөн өдөр тэмдэглэх, шинээр гэр бүл болох, шинэ хүүхэдтэй болох, баяр ёслол тэмдэглэн өнгөрүүлэх, урамшуулал олгогдох, сахилгын шийтгэл оноогдох зэргийг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэгдэн хэрэгжүүлж ажилласан.	90%	
13	Ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг шинэчлэх	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн гэрээг нэг жилийн хугацаатайгаар шинэчлэн байгуулж нэг жилийн ажлын үр бүтээл, гүйцэтгэлийг харгалзан гэрээг сунгадаг зарчимд шилжсэн.	100%	
14	Тушаал шийдвэр, албан бичгийг бичиг хэргийн стандартын дагуу боловсруулан архивлах	Тушаал шийдвэр, албан бичгийг бичиг хэргийн стандартын дагуу боловсруулан архивлав.	90%	товъёо хийн үдэхэд бэлэн болсон
15	Компанийг бичиг баримтжуулах	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд гүйцэтгэх захирлын нэрийг нэмэлтээр оруулсан. ЧМХЦ, 13-р зуун цогцолборуудын галын дүгнэлтийг хөөцөлдөж шинээр гаргуулсан. Стандарт хэмжил зүйн газраас тохирлын гэрчилгээ шинээр авсан. ЧМХЦ архины зөвшөөрлийг сунгуулан, 13-р зуун цогцолборт улирлын ачааллын үе эхлэхэд архины зөвшөөрөл авахад бэлэн болгож хөөцөлдсөн.	100%	



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА